



\*\*\*\*\*Нислэгтэй аялал

# Далай дээжид зочлох аялал

Аяллын маршрут:

- Хөвсгөл далай
- Хүслийн хад
- 50/100 солбилцол
- Лэйк форест гэр бүлийн цогцолбор амралтанд байрлана.

Үнэ ердөө:

**1349K**

**ЗАХИАЛГА**

99025761. 95011166

[www.sales@jamogrand.com](mailto:sales@jamogrand.com)



**Safe  
travels**

## ӨДӨР 1 УБ-ХӨВСГӨЛ



боловч үүнээс биечлэн очих боломжтой цорын ганц цэг нь Хөвсгөл аймагт байдгаараа онцлогтой. Энэ онцгой газарт цуглаж, энерги хуримтлуулаад аяллаа цааш үргэлжлүүлэн хөх цэнхэр Хөвсгөл далайн эрэгт байрлах Лэйк Форест Лодж дээр байрлана. Далайн эрэг рүү тольдон харах буудлын өрөөндөө орж тухлаад өдрийн хоолоо иднэ. Өдрийн хоолны дараа Хөвсгөл далайг дээрээс нь тольдон харах оргил өөд аажуухан алхахад ой хөвчийн цэвэр агаар сэнгэнэн үнэртэж, олон шувуудын жиргээнд сэтгэл баясдаг. Оргил өөд гарч Хөвсгөл далай ээжид дээж өргөж, хүслээ хэлээд баазын зүг буцна.

**ӨХ/ОХ** 2 цагийн нислэг,  
Улаанбаатар хотоос өглөө эрт нисч Мөрөнгийн нисэх онгоцны буудалд бууна. Хөвсгөл далайн зүг замдаа шууд гарна. Дэлхий дээр уртраг, өргөргийн 50°100° градус огтолцдог 4 цэг байдаг



## ӨДӨР 2 ХАТГАЛ ТОСГОН, ХӨВСГӨЛИЙН УДГАН, УСАН БООМТ

**ӨЦ/ӨХ/ОХ**

Өглөөний нарны элчинд ширээндээ тухлан сууж, нутгийн малчныхаас ирсэн шинэхэн өрөмтэй, боорцог идэж, аяга халуун цай уух зуурт алс хол аялсан алжаал тайлагдаж, энэ өдөртөө бүгдийг баяр жаргалтай хийх эрч хүч төрдөг. Өнөөдөр бид Хөвсгөл далайн эрэг дэх Хатгал тосгон, усан боомт, орон нутгийн музейгээр зочлоод буцах замдаа Хөвсгөлийн удганыд зочлох төлөвлөөгтэй. Хатгал тосгон сумын төвдөө цөөн тооны суурин иргэдтэй, тэдгээрийн дийлэнх нь усан боомтын ойролцоо сарлагийн хөөвөр, хонины ноос, цааны эвэр, шилмүүст модны үндсээр хийсэн гар урлалын эд зүйл борлуулан амьдардаг. Хатгалын төв дэх мэдээллийн төвөөр зочлоход Хөвсгөл далай ба Хорьдол сарьдагийн уулсын талаар маш олон зүйлийг сурч авдаг. Бааз руу буцах замдаа Хөвсгөлийн үе дамжсан удамт удганыд зочилж, сэтгэл чилээсэн зүйлсийг асууж тодруулах боломж бий. Оройн хоолноос урьтаад нуурын эрэг дагаад алхахад үнэхээр үзэсгэлэнтэй, амарлангуй байдаг.



## ХӨВСГӨЛ



Хөвсгөл аймаг нь хангайн уулархаг мужид оршдог. Мөнх цаст сүрлэг уулс гүн цэнхэр нурууд хөвч тайга өргөн уудам хөндий хосолсон байгалийн үзэсгэлэнт нутаг бөгөөд түүхийн дурсгалууд, олон төрлийн ховор ургамал, ан амьтан ихтэй Монголын Швейцарь хэмээн нэрлэгддэг билээ.

## ДАЛАЙ



Хөвсгөл далай нь гүнээрээ Азид хоёрт, талбайгаараа аравт ордог бөгөөд 2760 кв км талбайтай урт нь 136 км өргөн нь 36 км гүн нь 262м. Дэлхий дээрх 17 эртний далайн нэг бөгөөд 2 сая жилийн настай аж. Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газар нь Сибирийн тайга, төв азийн хээр тал бүсийн шилжилтийн хэсэгт хамардагаараа онцлогтой.




## ХҮСЛИЙН ХАД, ХӨВСГӨЛ НУУРЫН ХОЙГ



Өглөөний цайгаа тааваараа уусны дараа дуулга, түрийгээ өмсөөд туршлагатай морин хөтчийн зааврын дагуу мориндоо мордож хадан хавцлын зүг аялалдаа гарна. Тэндээс Хөвсгөл нуурыг бүхэлд нь харах үнэхээр үзэсгэлэнтэй. Бааздаа буцаж ирж өдрийн хоолоо идсэний дараа алжаалаа тайлан амарна.

Үдийн хоолны дараа моторт завиар хүслийн хадны зүг явна. Хөвсгөл нуурын баруун эрэгт хүрч, алс холыг зорьсон хэргээ бүтээгээд бааз руугаа буцна. Энэ өдөр нуурын эрэгт амрах сүүлийн өдөр тул өндөр уулс, өтгөн ой, цэнхэртэн үзэгдэх далайн өнгө нэг хөх цэнхэр, нэг номин ногоон болохыг ажин байгаль эхийн ер бусын үзэсгэлэнт төрхийг дурсамжиндаа үлдээн зураглаарай. Оройн хоолны дараа нуурын эрэгт байх түүдэг галын талбайд галын наадам хийж, мах шарж идэн дуу хууртай наргиа наадамтай дурсамжтай сайхан үдшийг өнгөрөөж энэ өдрийг үдээд амарна.



Монголын хамгийн олон хүн амтай аймаг бөгөөд Халх, Дархад, Хотгойд, Урианхай, Буриад-Тува, Цаатан гэсэн 6 ястан амьдардаг олон ястны өлгий нутаг. Дэлгэрхаан, Улаан тайга, Зүүн тайга, Мөнхсарьдаг, Саяан, Хорьдол сарьдаг зэрэг олон алдартай уул нуруудтай.

## ӨДӨР 4

## ӨЦ

## 1 цагийн нислэг

Өглөөний цайгаа тааваараа уугаад, ачаа тээшээ аажуухан базааж аваад Мөрөн хотын зүг давхина. Мөрөн хотын төв талбайгаар зочилж зургаа авхуулаад өдрийн цайгаа өөр өөрсдийн хүссэн газартаа ууна. /Энэ өдрийн өдрийн хоол аяллын үнэнд ороогүй/. Мөрөн хотын хүнсний захад төрөл бүрийн ургамал, жимс, цай гээд орон нутгийн онцлогтой бүтээгдэхүүнүүд их бий. Оройн 6 цагт онгоцны буудал руу хөдөлнө. Улаанбаатар хотын зүг буцна.

## АЯЛАЛД БАГТСАН

- Байр /1 өрөөнд 2 хүн байрлана/
- Мөрөн-Хатгал-Мөрөн чиглэлийн унаа
- Хөтөлбөрт дурьдагдсан хоол /ӨЦ-өглөөний цай, ӨХ-өдрийн хоол, ОХ-оройны хоол/
- Мэргэжлийн хөтөч тайлбарлагч
- Тусгай хамгаалалттай газрын тасалбарын үнэ, замын тасалбар

## АЯЛАГЧААС ГАРАХ ЗАРДАЛ

- Чингис Хаан Нисэх Онгоцны буудал хүргүүлэх, буудлаас тосох унаа
- Дээр дурьдаагүй хоол, ус, ундаа, шар айраг, архи, чихэр жимс, хуурай идэх зүйл зэрэг хувийн хэрэгцээний зардал, гарын мөнгө,
- Дээр дурьдаагүй хоол